



**2023 ОНЫ А/133 ТООТ НИЙГМИЙН ДААТГАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛЫН САНГИЙН ЯАМНЫ ДОТООД АУДИТЫН ХОРООНЫ
ЗӨВЛӨМЖИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ДАГУУ
ХИЙСЭН АЖЛЫН ТАЙЛАН**

2024.06.21
аймаг

Орхон

№	Журам, дүрэм, зааврын агуулга	Хэрэгжүүлсэн байдал
Нийгмийн даатгалын сангуудын захирал зарцуулалтад анхаарах асуудлаар		
1.8.	Нийгмийн даатгалын шимтгэлийн 121 хоногоос дээш насжилттай хуримтлагдсан авлагыг бууруулах талаар хийх ажлыг эрчимжүүлэх, өдөр тутмын үйл ажиллагаанд тавих шат шатны хяналтыг сайжруулахад анхаарч ажиллах;	Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2024 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн А/64 тоот “Нийгмийн даатгалын сангийн авлага барагдуулах ажлыг эрчимжүүлэх тухай” тушаалын дагуу үнэ эхний шимтгэлийн авлагыг 30-аас доошгүй хувиар бууруулах гэсний дагуу өмнөх оны жилийн эцэс, 2024 оны шимтгэлийн авлага 596 ААНБ-ын 5,576,596.43 мянган төгрөгийн авлагаас 2,124,705.17 мянган төгрөгийн авлагыг барагдуулсан ба 38.10 хувийн гүйцэтгэлтэй ажилласан байна. Уулзалтаар - 284 ААНБ-ын 530.7 сая төгрөгийн өр авлагыг талаар уулзалт хийж холбогдох хариуцлага болон дараагийн авах арга хэмжээг танилцуулсан. Хуваарь гаргаж -3 ААНБ-тай 973,924.72 мянган төгрөгийн авлага барагдуулах гэрээ байгуулан тус ААНБ-ууд 374,662.06 мянган төгрөгийг санд төлж гэрээний биелэлтээ ханган ажиллаж байна. Данс хаасан - 48 ААНБ-ын 514,685.90 мянган төгрөгийн авлагатай холбоотойгоор байгууллагын харилцах данс хааснаар 4 ААНБ-ын 81,870.78 мянган төгрөгийн авлагыг бууруулан ажилласан байна. Албан шаардлага - 9 ААНБ-ын 40,338.31 мянган төгрөгийн авлагад шаардлага хүргүүлснээр 2 ААНБ-ын 2,139.20 мянган төгрөгийн авлага барагдуулсан байна. Прокурорт шилжүүлсэн - 2 ААНБ-ын 93,877.30 мянган төгрөгийн авлагад Зөрчлийн тухай хуулийн дагуу хялбаршуулсан журмаар зөрчил шалган шийдвэрлүүлэхээр материал хүргүүлсэн байна.
1.10.	Нийгмийн даатгалын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1, 11 дүгээр зүйлийн 11.5 дахь заалтыг хэрэгжүүлэн хөрөнгийн үр өгөөж, ашиглалтыг сайжруулах, сангийн орлогыг нэмэгдүүлэх арга хэмжээ авах;	2023 оны мөн үед 1383 ажил олгогч байгууллагын 26597 даатгуулагч, энгийн болон малчин, даатгуулагч эх нийт 4399 даатгуулагчийн нийт 69,826,846.12 мянган төгрөгийн шимтгэлийн орлогыг санд төвлөрүүлж байсан бол энэ онд 1367 ажил олгогч байгууллагын 26597 даатгуулагч, энгийн болон малчин, даатгуулагч эх нийт



		<p>5330 даатгуулагчийн нийт 80,030,383.82 мянган төгрөгийн шимтгэлийн орлогыг санд төвлөрүүлж өмнөх оноос 14.6 хувиар давуулан биелүүлж ажиллалаа.</p> <p>2024 оны эхний хагас жилийн байдлаар орлогын төлөвлөгөө 85,802,973.10 мянган төгрөгөөр батлагдсаныг 80,030,383.82 мянган төгрөгийн орлого төвлөрүүлж биелэлт 93.27 хувьтай байна.</p>
1.11.	Тэтгэврийн хувийн хэргийн бүрдлийн бүрэн бүтэн байдал, хадгалалт, хамгаалалтыг сайжруулах;	<p>2024 оны эхний хагас жилийн байдлаар өндөр насны тэтгэвэр, цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэжээгчээ алдсаны тэтгэврийн өөрчлөн тогтоолт болон тэтгэвэр тогтоолгоноос хойш шимтгэл төлж ажилласан жилийн нэмэгдэл хийлгэх 449 өргөдөл ирсэн ба шийдвэрлэсэн өргөдлүүдийг тухай бүр хувийн хэрэг хийж цэгцэлсэн.</p> <p>Хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр авагч өндөр насны тэтгэвэрт шилжихээр ажилласан жил шалгуулах 102 өргөдөл ирж тэтгэврийн хувийн хэргийг шалган цэгцэлсэн ба хуучирсан хувийн хэргийн хавтсыг шинэчлэн сольж бүрэн бүтэн байдлыг шалгаж ажилласан.</p> <p>Хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэврийн сунгалтын 1081 акт, тэжээгчээ алдсаны тэтгэврийн сунгалтын 54 тодорхойлолт ирсэн ба үүнээс энгийн хугацаа сунгагдсан актуудыг тухай бүр хувийн хэрэгт хийж үдэж цэгцэлсэн. Цэргийн ХЧА тэтгэвэр, хувь өөрчлөгдсөн ХЧА тэтгэвэр, 1995 оноос өмнөх ХЧА тэтгэврүүдийг шинэ программд оруулаагүй тул хувийн хэрэгт үдээгүй хүлээгдэж байна.</p> <p>2024 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс хойш тогтоогдсон шинэ тэтгэврийн хувийн хэргүүдийг хүсэлтийн дугаарын огноогоор түр хайрцагласан ба хувийн хэргийн дугаарлалт тодорхойгүй байгаа тул тэтгэврийн архивт шилжүүлээгүй хүлээгдэж байна.</p> <p>Орхон аймгийн Нийгмийн даатгалын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгчийн 2024 оны 01 дүгээр сарын 19-ний өдрийн “Тэтгэвэр авагчийн хувийн хэргийн баримтад тооллого хийж, тэтгэврийн олголт шалгах тухай” А/03 тушаалын дагуу ажлын хэсэг нийт тэтгэвэр авагчдын хувийн хэргийн бүрдлийг шалган бүрэн байдлыг ханган, олголтыг шалгаж, тэтгэвэр авагчийн</p>



		хувийн хэргийн муудсан хавтсыг шинэчлэн сольж бүрэн бүтэн байдлыг ханган ажилласан.
1.12.	Архивын лавлагаа, шүүхийн шийдвэрийг хуурамчаар гаргуулан тэтгэвэр тогтоолгосноос нийгмийн даатгалын санд их хэмжээний хохирол учруулах магадлалтай байх тул холбогдох байгууллагуудтай хамтран ажиллах, мэдээлэл солилцох тогтолцоог бий болгох;	Архивын лавлагааны үндэслэлийг анхан шатанд материал хүлээн авсан байцаагч тухай бүр шалгаж, тэтгэврийг тогтоодог. Малчин даатгуулагчийн А дансны лавлагааны үндэслэлийг сум бүрт тухайн сумын “Даатгуулагчийн малчнаар ажиллаж, нийгмийн даатгалын шимтгэл төлсөн хугацааг тодорхойлох зөвлөл”-ийн нарийн бичиг шалгаж баталгаажуулдаг. Мөн 2017 оноос эхлэн Орхон аймгийн Шүүхийн тамгын газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх алба хорих 437 дугаар анги, Аймгийн засаг даргын тамгын газар, Аймгийн архивын тасагтай хамтран ажиллах санамж бичиг байгуулсан тухай бүр шаардлагатай лавлагааны үндэслэлийг шалгаж хэвшсэн. 2024 онд эхний хагас жилийн байдлаар шүүхийн шийдвэрийн үндэслэлд дурьдсан 2, аймгийн архиваас гаргасан 1 лавлагааны үндэслэл шалгасан.
1.13.	Тэтгэмж авагчдын цалин хөлсний дунджийг зөв тооцоолох, ажилгүйдлийн тэтгэмжийг тогтоохдоо даатгуулагчийн сүүлийн бүтэн ажилласан гурван сарын хөдөлмөрийн хөлс түүнтэй адилтгах орлогоос тооцож, хувийн хэрэгт тогтоосон, баталсан, зөвшөөрсөн, хянасан, албан хаагчдын гарын үсгийн бүрдлийн бүрэн хангуулах;	2023 онд нийт 821 даатгуулагчийн 2.9 тэр бум төгрөгийн ажилгүйдлийн тэтгэмжийг 2 байцаагч бодож тогтоон хяналтын байцаагч, тасгийн даргаар хянуулж, Ахлах нягтлан бодогч, газрын даргаар зөвшөөрсөн гарын үсгийн бүрдлийг бүрэн хангаж олгож байна. 2024 оны эхний хагас жилийн байдлаар шинээр нийт 361 даатгуулагчид ажилгүйдлийн тэтгэмж тогтоож өссөн дүнгээр 1645 даатгуулагчийн 1,660.1 сая төгрөгийн ажилгүйдлийн тэтгэмжийг сар бүр шилжүүлж, тэтгэмжийн 2 байцаагч бодож тогтоон тооцоог хийж хяналтын байцаагч, тасгийн даргаар хянуулж, Ахлах нягтлан бодогч, газрын даргаар зөвшөөрсөн гарын үсгийн бүрдлийг бүрэн хангаж олгож байна
1.14.	Ажилгүйдлийн тэтгэмж авагчийн тэтгэмж авах хугацаа дуусгавар болсон тохиолдолд тэтгэмжийн олголтыг зогсоон тооцоог үнэн зөв хийж, хувийн хэргийг хааж, архивт шилжүүлэх;	2023 онд ажилгүйдлийн тэтгэмж авч дууссан 721 даатгуулагчийн тооцоог хийж дуусган, дугаарын дагуу үдэж цэгцлэн 40 ширхэг боть баримт архивт хүлээлгэн өгснөөс ажилгүйдлийн тэтгэмж авч байгаад ажилд орсон 5 иргэний илүү олгосон 1.2 сая төгрөгийн тэтгэмжийг улсын байцаагчийн актаар нөхөн төлүүлж санг хохиролгүй болгон ажилласан.



		2024 оны эхний хагас жилийн байдлаар ажилгүйдлийн тэтгэмж авч байх хугацаандаа ажилд орсон 5 иргэнд илүү олгосон 3.9 сая төгрөгийн тэтгэмжийг буцаан төлүүлээд байна.
1.15.	Шүүхийн шийдвэрээр ажилдаа эгүүлэн томилогдон, ажилгүй байх хугацааныхаа цалинг нөхөн авсан иргэдийн мэдээллийг холбогдох байгууллагаас авч тухайн даатгулагчийн ажилгүй байх хугацаанд авсан ажилгүйдлийн тэтгэмжийг санд буцаан төлүүлэх арга хэмжээ авах;	Шүүхийн шийдвэрээр ажилдаа эгүүлэн томилогдон, ажилгүй байх хугацааныхаа цалинг нөхөн авсан 1 иргэний ажилгүй байх хугацаанд авсан 2,006,848.00 төгрөгийн ажилгүйдлийн тэтгэмжийг буцаан төлүүлэхээс эхний хагас жилийн байдлаар 400,000.00 төгрөгийг санд буцаан төлүүлж, үлдсэн төлбөрийг үлдсэн саруудад сар бүр хуваан төлүүлэх арга хэмжээ авч ажиллаж байна.
Мэдээллийн цахимжилт, ил тод байдлын талаар		
1.25.	2006 оноос өмнөх ажилласан жилийн лавлагааг цахим мэдээллийн санд оруулж, хөгжүүлэлт хийх;	Нийгмийн даатгалын Ерөнхий газраас 21 аймаг, 9 дүүргүүдийн Нийгмийн даатгалын хэлтэст хадгалагдаж буй ажил олгогчийн нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн НД-7, НД-8 тайланг цахимжуулах ажилтай холбогдуулан “Ай Ти Зон” ХХК-ний ажлын хэсэг Б.Чаминчимэг, Г.Тэмүүжин, О.Дашням нарт Орхон аймгийн Нийгмийн даатгалын хэлтэст хадгалагдаж буй 1995-2005 оны 189 хайрцаг, 3301 хадгаламжийн нэгж, нийт 73870 хуудас баримтыг шалган, тоолж “Баримт шилжүүлсэн акт” үйлдэн 2020 оны 03 дугаар сарын 29-ний өдөр бүрэн хүлээлгэн өгч ажиллалаа. Мөн баримт үдэж, хавтаслахад шаардлагатай 40 ширхэг бор хавтас хүлээлгэн өгсөн. Уг ажлыг гүйцэтгэх явцад хадгаламжийн нэгжийн бүртгэлд орсон боловч уг хадгаламжийн нэгжид баримт бүртгэгдээгүй 3, тухайн онд аж ахуйн нэгж байгууллагын тайлан 2 хадгаламжийн нэгжээр бүртгэгдсэн ба түүнийг нэгтгэх 2 тохиолдлууд тус тус гарсан бөгөөд нийтдээ дараалласан 3305 хадгаламжийн нэгжээс 4 тоог хасаж, 9576 гэсэн шинэ хадгаламжийн нэгж нэмж ажилласан. Байнгын болон НДШ-ийн баримт тус бүр дээр, ТҮР болон 70 жил хадгалагдах баримтын хайрцаг тус бүр дээр нийт 253 ширхэг баркод шошго нааж системд бүртгэсэн. Нийт 852 баримт хүлээж авснаас байнгийн 268 баримтыг цаасан сууриас цахим мэдээллийн хэлбэрт шилжүүлж, Ажилтан албан хаагчдаас баримт хүлээн авахдаа дотоод товъёгийн дагуу иргэн



		болон байгууллагын нэр, регистрээр данс бүртгэлээ үүсгэж, данс бүртгэлийн нэр төрлийн бүртгэлийг бүрэн бүртгэж хөтөлдөг болсон.
1.27.	Ажил олгогчийн нийгмийн даатгалын шимтгэлийн тайланг цаасаар хүлээж авахгүйгээр цахим хэлбэрт бүрэн шилжүүлэх арга хэмжээ авч ажиллах;	2023 онд тоон гарын үсгээр 11858 тайлан, нийт 15675 нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайланг Нийгмийн даатгалын шимтгэлийн тайлан хянан баталгаажуулах журмын дагуу хүлээн авч хэрэгжилтийг ханган ажиллаж өмнөх оны мөн үетэй харьцуулахад идэвхтэй тайлан ирүүлдэг аж ахуйн нэгж байгууллагын 75 хувь тоон гарын үсгээр хүлээн авч хэвшүүлэн ажилласан. 2024 онд 1367 аж ахуйн нэгж байгууллагын нийгмийн даатгалын шимтгэлийн тайланг шинэ СИКОС системд цахим хэлбэрээр хүлээн авч мөн журмын дагуу цаасан тайланг баталгаажуулан ажилласан байна.
Батлагдсан төсөв, үйл ажиллагааны зардлын талаар		
1.28.	Ажилтан, албан хаагчдын хагас жил, жилийн эцсийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан зорилт, арга хэмжээ тус бүрээр үнэлж, хариуцлага хүлээлгэх, урамшууллыг тооцох;	Тус газрын төрийн жинхэнэ албан хаагчдын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг оны эхэнд батлан ажиллаж, журамд заасны дагуу төлөвлөгөөний гүйцэтгэлд хяналт тавих болон хангалтгүй байгаа зорилт, арга хэмжээний биелэлтийг хангуулах зорилгоор албан хаагчидтай хийх явцын ярилцлагыг улиралд 1-ээс доошгүй удаа зохион байгуулж ажилласан бөгөөд албан хаагчдын хагас жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтэд зорилт арга хэмжээ тус бүрээр үнэлж хяналт, шинжилгээ үнэлгээ хийж ажиллалаа. “Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх журам”-ын 6.4 дэх хэсэгт заасны дагуу тус газрын үнэлгээний баг 06 дугаар сарын 25-ны дотор үнэлгээг эцэслэн баталгаажуулна. Ажилтан албан хаагчдын хагас жилийн үр дүнгийн урамшуулалд олгох санхүүжилтийн хэмжээ 29,991,600.00 төгрөг байна.
1.29.	Сумдын байцаагч нарын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг тухайн сумын Засаг даргын Тамгын газрын даргаар баталгаажуулсан тохиолдолд ажлын үр дүнг үнэлэх;	Жаргалант сумын байцаагч Н. Болортуяагийн 2023 оны гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлтийг Жаргалант сумын Засаг даргын тамгын газрын дарга Т.Энхжаргал даргатай зөвшилцөж, хамтран үнэлгээ хийсэн.



1.30.	Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2017 оны “Журам батлах тухай” 24 дүгээр тогтоолоор баталсан “Нийгмийн даатгалын төлөөлөгч ажиллуулах журам”-д заасны дагуу ажил үүргийг гүйцэтгүүлэх, Нийгмийн даатгалын орон тооны бус төлөөлөгчийн хэрэгжүүлсэн ажлын тайланд хяналт тавьж ажиллах;	2024 онд Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд асарч байгаа 430 иргэний судалгааг холбогдох газраас нь авч 140 иргэнд хамрагдах талаар мэдээлэл хүргэсэн. Сайн дурын даатгалд даатгуулсан 3775 иргэнээс эхний улиралд гэрээний хугацаа дуусаж байгаа 1657 иргэнтэй холбогдож гэрээний хугацааны болон шимтгэл төлөлтийн талаар мэдээллийг өгч, 2024 онд шинээр малчнаар сайн дурын даатгалд хамрагдах 584 малчин өрх, туслах малчны 44, мал бүхий 202 өрхийн судалгааг холбогдох газраас авч ажилласан.
1.31.	Ажилтнуудын эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх, ажлын хариуцлагыг өндөржүүлэх, албан хаагчдыг мэргэшүүлэх талаар шат дараатай арга хэмжээ авах;	2024 оны эхний хагас жилийн байдлаар нийт дотоодын 54 удаагийн сургалтанд давхардсан тоогоор 907 ажилтан албан хаагчдаа хамруулан ажиллалаа. Үүнээс: <ul style="list-style-type: none">• Авилга ашиг сонирхлоос урьдчилан сэргийлэх, Нийгмийн даатгалын багц хуулийг хэрэгжүүлэхэд анхаарах асуудал, Байгууллагын үйчилгээний стандарт, харилцаа хандлага, ёс зүйн талаарх 17 цахим удаагийн сургалтанд давхардсан тоогоор 115 албан хаагч• Хүний эрхийн үндэсний комисс, Улаан загалмайн нийгэмлэг, Орхон эм хангамж, Эрүүл мэндийн газар, Эрүүл мэндийн даатгалын газар, Төрийн албаны зөвлөл, Насан туршын боловсрол, ХГБХХГ, АЗДТГ-ын ХШҮХХ, Хөгжлийн шийдэл ТББ зэрэг байгууллагуудтай хамтран 37 удаагийн танхим сургалтанд давхардсан тоогоор 792 албан хаагч Филиппин улсад Азийн бүтээмжийн төвөөс зохион байгуулсан. "Төрийн байгууллагын бүтээмж" сэдэвт олон улсын сургалтад 1 албан хаагч хамрагдсан.
1.32.	Дотоод хяналтын үр нөлөөг улам сайжруулах талаар ажил зохион;	2024 онд дээд газраас ирүүлсэн чиглэлийн дагуу шилэн данс, өргөдөл гомдлын шийдвэрлэлт, стандартын сайжруулалт, 2 зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж 5 тайлан, 1 судалгааг гарган дээд газарт хугацаанд нь хүргүүлж, 100% ханган биелүүлэн ажилласан байна. Нийтийн ил тод мэдээллийн байдлын тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавьж цахим хуудсанд бүрэн оруулаагүй дутуу оруулсан 8.2.8, 8.2.9, 8.3.1 мэдээллийг



		<p>бүрэн оруулж, шинэчлээгүй байсан 8.2.2, 8.2.6, 8.3.2, 8.3.3, 8.3.4, 8.3.6, 8.5.1 мэдээллийг шинэчлэн оруулж байгууллагын нээлттэй 48 мэдээллийг бүрэн оруулж, мэдээллийн самбарт байршуулан ил тод болгож, иргэдийн мэдээлэл хайх, хүлээж авах эрхийг ханган ажилласан.</p> <p>Шинэ программ нэвтэрч байгаатай холбоотой шинээр тогтоосон 488 тэтгэвэр, 214 тэтгэвэртэй холбоотой өргөдөл, ЭММЗ-ын 524 актны сунгалт, 5078 даатгуулагчийн тэтгэмж, 490 ажилгүйдлийн тэтгэмжийг тус тус хянаж ажилласан.</p>
1.34.	Төрийн хэмнэлтийн тухай хуулийг чанд мөрдөж ажиллах, анхан шатны бүрдэл дутуу баримтаар гүйлгээ хийдэг зөрчлийг таслан зогсоох арга хэмжээ авч ажиллах;	Төрийн хэмнэлтийн тухай хуульд заасны дагуу байгууллагын зардлын гүйлгээ тус бүрийг аймгийн төрийн сангийн хэлтэс болон төрийн аудитын газрын холбогдох мэргэжилтнээр хянуулж баталгаажуулж байна. Мөн зардал тус бүрийг зардлын ангилалын зориулалтын дагуу зарцуулж өр, авлаггүй ажиллаж байна.
1.37.	Харилцагч иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас худалдан авсан бараа, ажил үйлчилгээнд төлбөрийн баримт аваагүй зөрчлийг давтан гаргахгүй байх;	Харилцагч иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас худалдан авсан бараа, ажил үйлчилгээнд төлбөрийн баримт аваагүй зөрчил гараагүй.